

**УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 06 ДУГЭЭР САРЫН 12-НЫ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛ**

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	хувь
1	Хөдөөгийн багийн хог хаягдал, малын сэг зэмийг устган, цэвэрлэх ажлыг эрчимжүүлэх талаар багийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өгөх	2023.06.26	<p>Сүмбэр сумын 4 болон 5 дугаар баг нийт 95 тонн хог хаягдал, малын сэг зэмийг устгалд оруулж ариутгал хийсэн. 6 дугаар багийн сэг зэм устгалын ажил 06 сарын 23-ны өдөр хийгдэж байна.</p> <p>Баянтал сум 2 удаагийн сэг зэм устгах ариутгах ажил хийгдсэн ба нийт 375 малын сэг зэм, 72 кг ариутгалын бодисоор халдваргүйжүүлэлт хийсэн.</p> <p>Шивээговь суманд гарсан бог малын мялзан өвчний устгалд 2023 оны 6сарын10-ны өдөр Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн ажлын албатай 2 өрхийн 7 өвчтэй малыг ариутгал халдваргүйжүүлэлт хийж булж устгасан..</p>	90
2	Авто замын тэмдэг, тэмдэглэгээг сэргээн засварлах, шинээр байрлуулах ажлыг эрчимжүүлэн, замын эвдрэл гэмтлийг засварлах талаар “Саруул харгуй” ХХК-ны удирдлагад үүрэг чиглэл өгөх.	2023.06.26	<p>“Саруул харгуй” ХХК нь Улаанбаатар-Чойр А-0101, Чойр-Сайншанд А-0102 дугаартай олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замыг хариуцан ажилладагтай холбоотойгоор тэмдэг тэмдэглэгээ сэргээн засварлах, шинээр байгуулах ажлыг эрчимжүүлэн, замын эвдрэл гэмтлийг засварлах ажлуудыг шуурхай зохион байгуулж ажиллах талаар сумын Засаг даргын Орлогчийн 2023 оны 06 сарын 19-ны өдрийн В/420 албан тоотыг хүргүүлсэн.</p> <p>2023 оны 4 дүгээр сарын 11-ны өдрөөс эвдрэл гэмтлийг засварлах ажлыг эхлүүлэн 27 км замыг засварлан гүйцэтгэл 62 хувьтай явагдаж байна. Замын тэмдэг тэмдэглэгээг 7 сарын эхний 7 хоногт хийж дуусгах төлөвлөгөөтэй байна.</p>	70
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний гэрээний талаарх явцыг танилцуулах	2023.06.26	<p>Нэгдсэн эмнэлгийн зүгээс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт өндөр өртөгтэй тусламж үйлчилгээг үзүүлэх гэрээг байгуулахаар холбогдох баримт материалыг бүрдүүлэн хүргүүлсэн. ЭМДЕГ-с хариу ирүүлээгүй байна.</p>	30

4	Хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлж ажиллахад анхаарч ажиллах.	2023.06.26	2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, бараа тоног төхөөрөмж худалдан авах ажлын хүрээнд Сүмбэр сум нийт 15 ажил, Баянтал сум нийт 12 ажлыг 07 сарын 01-ны дотор тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Шивээговь сумын хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын явцыг эрчимжүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар 6 үнэлгээний хороо байгуулж, тендерүүдийг зарлаад байна. .	50
5	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаар танилцуулах.	2023.06.26	Сүмбэр сум өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд малчдад албан даалгавар болон ногоон тэжээл тариалалтын заавар зөвлөмжийг өгч 2023 оны сумын аюулгүй нөөцөд 50 тн өвс, 20 тн тэжээл бэлтгэх, багуудын өвс тэжээлийн агуулахыг сэргээн засварлахаар төсвийг тооцоолон батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан.  Шивээговь сум өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө боловсруулахаар сумын Засаг даргын Орлогч даргын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 2/226 дугаар тоот албан бичгээр төсвийн 7 байгууллагад үүрэг өгсөн.  Баян тал сумын хувьд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, холбогдох албан байгууллагуудад хүргүүлсэн	30
6	Мал төллөлтийн үеэр малчин өрхийн хүүхдүүдийг гэр цэцэрлэгт хамруулах талаар судлаж танилцуулах	2023.06.26	Мал төллөлтийн үеэр малчин өрхийн хүүхдүүдийн гэр цэцэрлэгт 4,5,6-р багийн 2-5 насны 212 хүүхдийг малчдын хүүхдийг хамруулах шаардлагатай. Одоогоор цэцэрлэг ажиллуулах асуудал шийдвэрлэгдээгүй.	0
7	Аймгийн баяр наадам 2023 оны 07 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулагдана коммисын гишүүд бэлтгэл ажлын ханган	2023.06.26	Аймгийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А/185 дугаар захирамжаар аймгийн баяр наадмын коммис томилогдон 2 удаа хуралдаж, бэлтгэл ажлын төлөвлөгөө, төсвийг гарган салбар коммисуудад үүрэг чиглэл өгсөн.	70

	чанартай зохион байгуулах.			
8	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр болно иргэдийн санал өгүүлэх, ирцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах.	2023.06.26	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд: Сүмбэр сум-39.9 хувь Шивээговь сум-35.5 хувь 11 байгууллагын нөхөн сонгуульд хамрагдсан ирц-90.2 хувь	90
<b>Дундаж</b>				53.7

2023 оны 06 дугаар сарын 26-ний өдөр

**Хянасан:** ХШҮ-ний хэлтсийн дарга:

М.АНХБАЯР

**Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:**  
ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн

Б.МӨНХЗАЯА